

+`



ТӨВ АЙМГИЙН ЭРДЭНЭ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

ТАБ-ын Дарга, тэргүүлэх аудитор

Л.Жаргалсайхан

И-мэйл: jargsaihan_tuv@yahoo.com

Утас: 70272582

Факс: 01-272-22582

Аудитын тайлан

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

Аудитын менежер:

О.Амаржаргал

И-мэйл: amaraa_tuv@yahoo.com

Утас: 70273465

Ахлах аудитор Т.Майцэцэг

Утас: 70273204 99018619

И-мэйл: maits2009@yahoo.com

Аймгийн аудитын газрын хаяг:

Төв аймаг Зуунмод сум 1-р баг

Төрийн байгууллагуудын ордон

Цахим хуудас: www.audit.mn

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
8. Шилэн дансны мэдээлэл
9. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
11. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Нэг. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.3, Төрийн аудитын тухай хуулийн 15.1.2 дахь заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дүгээр зүйлд заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төв аймгийн Эрдэнэ сумын Засаг даргын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд ТӨВ-2017/21/СТА-ТШЗ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Төв аймгийн Эрдэнэ сумын Засаг дарга 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт/УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Төв аймгийн Эрдэнэ сумын Засаг дарга, 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитыг 2017 оны 03 дүгээр сарын 20-наас 2017 оны 03 дүгээр сарын 25-ныг хүртэл хийхээр төлөвлөн ТАБ-ын аудитын багийн гишүүн аудитор Т.Майцэцэг хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Төв аймгийн Эрдэнэ сумын Засаг дарга, 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг 2017 оны 03 дугаар сарын 20-нд ТАБ-т ирүүлсэн байна.

Төрийн аудитын байгууллага аудитыг 2017 оны 03 дүгээр сарын 20-наас 2015 оны 03 дүгээр сарын 22-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2017 оны 03 дугаар сарын 25-нд Төв аймгийн Эрдэнэ сумын Засаг дарга удирдлагад гардуулна.

Хоёр. Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Төсвийн төвлөрүүлэн захирагч нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэр, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, ТБОНАХБАҮХАТХууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Гурав. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэр, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.-т “Аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвийн орлогын нэр төрөл, зарлагын ангилал, санхүүжилтийн зориулалт болон төсөв зохиох, батлах, гүйцэтгэлийг зохион байгуулах, тайлагнах үйл ажиллагааг төсвийн болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулна.”, мөн хуулийн хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга харьяалах нутаг дэвсгэртээ дараахь нийтлэг бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

29.1.1.төлөвлөлт, төсөв, санхүү, бүртгэл тооцооны талаар: а/нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн хэтийн зорилт болон жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл, гүйцэтгэлийн тайлан, орон нутгийн төсвийн болон түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлуулахаар тухайн Хуралд оруулах, батлагдсан хөтөлбөр, төсөв, төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах; гэж тодорхойлсон байна.

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1.36-д “төсвийн ерөнхийлөн захирагч” гэж өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсвийг төлөвлөх, батлагдсан төсвийг хууль тогтоомжийн дагуу хуваарилах, хяналт тавих, захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг” хэлнэ гэж заасны дагуу Төв аймгийн Заамар сумын Засаг дарга буюу ерөнхийлөн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна.

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.7 “өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн бусад байгууллага, Засгийн газрын тусгай сан, гадаадын зээл, тусламжаар хэрэгжсэн төслийн тайлан бүхий хагас жилийн болон жилийн эцсийн санхүүгийн тайланг нэгтгэн, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх” бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

Мөн хуулийн 14.3 Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна.

Засаг дарга нь дээд шатны төсөвт тодотгол хийсний улмаас тухайн шатны төсөвт тодотгол хийх зайлшгүй шаардлага бий болсон, урьдчилан тооцох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурах, зарлага нэмэгдэж, орон нутгийн төсөв алдагдалтай болох нөхцөл байдал бий болсон тохиолдолд тухайн жилийн төсвийн тодотголыг боловсруулж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлнэ.

Аймаг, нийслэл, сум дүүргийн Засаг дарга энэ хуулийн 61.1-д заасан төлөөлөн хэрэгжүүлэх чиг үүрэг бүрээр санхүүжилтийн хуваарилалт хийх саналаа орон нутгийн төсвийн төслийн хамт бэлтгэж, хуульд заасан хугацааны дотор зохих шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлнэ.

Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйл.Төсвийн төвлөрүүлэн захирагч, түүний бүрэн эрх 15.4.1-д төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8–д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх гэж заасны дагуу Төв аймгийн Бүрэн сумын Засаг дарга Төсвийн төвлөрүүлэн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна. Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон төвлөрүүлэн захирагчийн төсвийг аймаг, сумын ИТХурлаас баталж аймгийн Төрийн сангаас олгож байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэр, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, НББ-ийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг мөрдөн ажиллаж байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан

Дөрөв. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нийцлийн аудитын стандарт 4200, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Төв аймгийн Эрдэнэ сумын Засаг дарга, 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд дүгнэлт өгөх үүднээс Төв аймгийн Эрдэнэ сумын Засаг даргын удирдлагын бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд орон нутгийн төсвийн орлогын болон тусгай зориулалттай сангуудын дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын батлагдсан төлөвлөгөөний дагуу гүйцэтгэлийн шатанд орон нутгийн төсвийн орлогын болон тусгай зориулалттай сангуудын мөнгөн хөрөнгө, орлого, зардлын дансад горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад Санхүүгийн нэгтгэсэн тайланд баримтлах нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй байна. Төсөвт байгууллагуудад нягтлан бодох бүртгэлийн бодлоготой ажиладаг байна. Санхүүгийн нэгтгэсэн тайланг Засгийн газрын төсвийн гүйцэтгэлийн Э-тайлангийн нэгтгэлээр нэгтгэгдсэн санхүүгийн тайланг ирүүлж байна.

Төсвийн шууд захирагчид ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Төв аймгийн Эрдэнэ сумын Засаг даргын төсвийн нэгтгэсэн санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг тодоруулахад Дэлхийн банкны төслийн хүрээнд хөгжлийн өнөөгийн шаардлагад нийцсэн интернетэд суурилсан программ хангамжийг ашиглан “Санхүүгийн тайлангийн Э-тайлан” программаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

Тав.Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Тус сум нь дотоод хяналтын ажлын хэсэг нь Орон нутгийн байгууллагуудын үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтын тайланг ирүүлсэн. Сумын хэмжээнд хөрөнгийн тооллого, өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалт зэрэг санхүүгийн механизмыг бүхэлд нь хянадаггүй байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, түүнийг хэрэгжүүлэхээр гаргасан заавар, журмыг хэрэгжүүлж, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг Засгийн газрын төсвийн гүйцэтгэлийн Э-тайлангийн нэгтгэлээс боловсруулж байна. Эдгээр журам нь УСНББОУС-тай нийцсэн байна.

Зургаа.Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

Батлагдсан төсвийг хуваарийн дагуу Төв аймгийн Эрдэнэ сумын Засаг дарга Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан Тусгай зориулалтын шилжүүлгийн болон орон нутгийн байгууллагуудын санхүүжилт эх үүсвэрийг олгохоос гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваариалан гүйцэтгэлд хяналт тавьж ажилладаг байна.

Төсвийн орлого, эх үүсвэрийн талаар:

Сумын Засаг даргын өргөн барьсан 2016 оны төсвийн төслийг сумын ИТХ-ийн 2015.12.14-ний өдрийн 05 тоот тогтоолоор хэлэлцэн баталсан. Үүнд:

Сумын төсвийн татварын ба татварын бус орлого нийт дүнгээр 144396.4 мянган төгрөг, аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг 258631.0 мянган төгрөгөөр, ТЕЗ, түүний харьяа байгууллагуудын төсвийг ИТХ -45225.2 мянган төгрөгөөр, ЗДТГазар -335963.8 мянган төгрөгөөр, ТЗШ-ийн байгууллагуудын төсвийг 1245845.5 мянган төгрөгөөр тус тус баталсан. Тайлант онд батлагдсан орлогын төлөвлөгөөг өөрчлөхөөр дараах байдлаар тодотгон баталсан.

Сумын ИТХ-ын 2016.05.18-ний өдрийн 05 тоот тогтоолоор ус рашаан ашигласны төлбөрийн орлогыг 6976.5 мянган төгрөгөөр тодотгон сумын ИТХ-ын цалингийн сан, НДШ-ийн шимтгэлийн зардалд тодотгон баталсан.

Сумын ИТХ-ын 2016.11.22-ний өдрийн 02 тоот тогтоолоор ҮАОрлогын албан татварын тасарсан орлогыг байгалийн ургамал ашигласны төлбөр, ус рашаан ашигласны төлбөр, хүү торгуулийн нэр төрлийн орлогоор нэр төрлийг тодотгон баталсан. 2016.12.16-ний өдрийн 03 тоот тогтоолоор сумын ИТХ-ын цалингийн сан, НДШ-ийн өр үүсч, 1609.8 мянган төгрөгийн санхүүжилт дутагдаж байгааг ойн төлбөрийн орлогоос санхүүжүүлэхээр тодотгон баталсан. Эдгээр тогтоолын дагуу өөрчлөлт оруулаагүй төсвийг тодотгон баталж байгаа нь Төсвийн тухай хуулийн 34-р зүйлийн 34.2.Засаг дарга дараах тохиолдолд тухайн жилийн төсвийн тодотголыг боловсруулж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлнэ:, 34.2.1.дээд шатны төсөвт тодотгол хийсний улмаас тухайн шатны төсөвт тодотгол хийх зайлшгүй шаардлага бий болсон:, 34.2.2.урьдчилан тооцох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурах, зарлага нэмэгдэж, орон нутгийн төсөв алдагдалтай болох нөхцөл байдал бий болсон:, 34.2.3.энэ хуулийн 29.7-д заасан үндэслэл бий болсон тохиолдолд батлагдсан хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төсөвт өртөгт өөрчлөлт оруулах. гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Сумын орон нутгийн төсвийн орлогын болон зарцуулалтын байдлыг авч үзвэл:

- ✓ Татварын байцаагчийн 2016 оны 12-р сарын төсвийн орлогын төлөвлөгөөний гүйцэтгэлийн мэдээгээр орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг нэр төрлөөр авч үзэхэд батлагдсан төлөвлөгөөний дагуу 13 нэр төрлийн орлогоор 151372.9 мянган төгрөг төвлөрүүлэхээс, гүйцэтгэлээр 13 нэр төрлийн нийт 137515.5 мянган төгрөг төвлөрч төлөвлөгөөний биелэлт 90.8 хувь байна.
13 нэр төрлийн орлогоос 3 нэр төрлийн орлого 100-аас дээш хувиар давж билэсэн. 10 нэр төрлийн орлого 46535.3 мянган төгрөгөөр тасарсан байна. Үүнд: үйл ажиллагааны орлого 82.8 хувиар буюу 29798.7 мянган төгрөгөөр, хөрөнгө борлуулсаны орлого 24.5 хувиар буюу 734.4 мянган төгрөгөөр, бууны орлого 48.6

хувиар буюу 1646.0 мянган төгрөгөөр, тэмдэгтийн хураамж 4.7 хувиар буюу 350.4 мянган төгрөгөөр, ойн төлбөрийн орлого 3.1 хувиар буюу 531.3 мянган төгрөгөөр, ашигт малтмал байгаль баялаг ашигласаны орлого 50.0 хувиар буюу 2500.0 мянган төгрөгөөр, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны орлого 36.4 хувиар буюу 4000.0 мянган төгрөгөөр, хог хаягдлын хураамж 17.2 хувиар буюу 803.0 мянган төгрөгөөр, төсөвт газрын өөрийн орлого 0.2 хувиар буюу 1.2 төгрөгөөр, нэр зааж ангилагдаагүй орлого 23.9 хувиар буюу 6170.2 мянган төгрөгөөр тус тус тасарсан байна.

Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлого батлагдсан төлөвлөгөөгөөр 586577.3 мянган төгрөг төвлөрүүлэхээс 519682.0 мянган төгрөг төвлөрч, батлагдсан төлөвлөгөөг 11.4 хувиар буюу 65955.3 мянган төгрөгөөр тасарсан байна. Нэр төрлийн хувьд авч үзэхэд 5 нэр төрлийн орлогоос 1 нэр төрлийн орлого биелэж, 4 нэр төрлийн орлого 3.4-69.0 хувиар тасарсан.

Улсын төсөвт төвлөрүүлэх 3 нэр төрлийн орлого батлагдсан төлөвлөгөөгөөр 88377.2 мянган төгрөг төвлөрүүлэхээс, гүйцэтгэлээр 77270.6 мянган төгрөг төвлөрч төлөвлөгөөний биелэлт 87.4 хувьтай байна. Нэр төрлөөр авч үзэхэд НӨАТатварын орлогын төлөвлөгөө 34.4 хувиар, агаарын бохирдлын төлбөр 40.9 хувиар тасарсан байна.

Зардлын гүйцэтгэлийн талаар:

Эрдэнэ сумын Засаг дарга 2016 онд батлагдсан төлөвлөгөөний дагуу тусгай зориулалтын шилжүүлгийн ЭМТөв-294235.3 мянган төгрөг, СӨБ- 180380.9 мянган төгрөг, ЕБСургууль-618519.7 мянган төгрөг, Соёлын төв- 59650.8 мянган төгрөг, Хувийн цэцэрлэг 70158.9 мянган төгрөгийн нийт 1222945.6 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Орон нутгийн байгууллагууд ИТХурал, ЗДТГазрын санхүүгийн дэмжлэгээр 258631.0 мянган төгрөг, сумын орон нутгийн төсвөөс 139917.7 мянган төгрөг нийт 398548.7 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон.

Нэмэлт санхүүжилтийн 44907.6 мянган төгрөгийн орлого эх үүсвэр төвлөрч зарцуулсан.

Тусгай сангуудын талаар:

Төв аймгийн Эрдэнэ сумын Засаг дарга нь ОНХСан, МХСан, Сум хөгжүүлэх сан, Байгаль хамгаалах сан, эм эргэлтийн сан, ГХУССан гэсэн тусгай зориулалттай сангуудын үйл ажиллагааг явуулсан байна. Эдгээр сангуудаас ОНХСангийн эх үүсвэрийг хууль тогтоомжинд нийцүүлэн сумын ИТХ-ын хуралдаанаас баталсан. МХСан, БХСан, ГХУССангуудын зарцуулах эрхийг Сангийн яамнаас Төрийн сангаар зарцуулах эрх суулгаагүй тул сумын ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлж, тус сангуудын үйл ажиллагаа оны эцэст хаагдсан байна.

1. СХСан нь 2016 оны эхэнд 9642.2 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байсан ба тайлант онд зээлдэгч иргэдээс 33881.4 мянган төгрөгийн зээл, зээлийн хүүгийн орлого төвлөрч, 5 иргэнд 22600.0 мянган төгрөгийн зээл, олгогдсон оны эцэст 20923.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан. СХСангийн зарцуулах эрхийг сумын ЗДТГазрын төлөвлөгөөнд 34642.2 мянган

төгрөгөөр төлөвлөн зарцуулах эрх олгогдсон ба гүйцэтгэлээр 22600.0 мянган төгрөгийг зарцуулсан.

2. МХСан оны эхэнд 1045.2 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн, 2601.0 мянган төгрөгийн өвсний авлага байсан. Тайлант онд сангуудын зарцуулах эрхийг Сангийн яамнаас Төрийн сангаар зарцуулах эрх суулгахгүй тул сумын ЗДТГазрын нэмэлт санхүүжилтийн дансанд нэгтгэж санг татан буулгасан. ЗДТГазарт 1045,2 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгө, 2601.0 мянган төгрөгийн авлагыг шилжүүлсэн.
3. БХСангийн 973.9 мянган төгрөгийг сумын ЗДТГазарт шилжүүлэн зарцуулсан.
4. ГХУССангийн бараа материалын эхний үлдэгдэл 1190.0 мянган төгрөгийг оны эцэст хасч тайлагнасан.
5. ОНХСан нь оны эхэнд 1836.2 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байсан ба тайлант онд 89380.1 мянган төгрөгийн санхүүжилт, 17191.5 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлого эх үүсвэр авч, 66508.6 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж оны эцэст 41899.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан. 2016 оны эхэнд 114017.8 мянган төгрөгийн, оны эцэст 98337.8 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй тайлагнагдсан.

Оны эхний авлагыг тодруулахад Хар арслан ХХК-аас 2014 онд хийгдсэн 3-р багийн цахилгааны шитны 62922.8 мянган төгрөг, Г.Отгонлхавгаас 2015 оны хийгдсэн ёслол хүндэтгэлийн өргөөний 15605.0 мянган төгрөг, Ганган нүүр ХХК – иас 2015 онд хэрэгжүүлсэн хүүхэд залуучуудын чөлөөт цагаа өнгөрөөх талбайн 31000.0 мянган төгрөг, аудитын газарт гэж аудитын төлбөрийг төлсөн 1390.0 мянган төгрөг, Энхцэцэгт өвсний 3100.0 мянган төгрөг нийт 114017.8 мянган төгрөгийн үлдэгдэл байсан.

Тайлант онд М.Доржсүрэн иргэнээс тэжээл хивэгний үнэ 6600.0 мянган төгрөгийн, Г.Отгонлхавгаас тайлант онд нэмж 8720.0 мянган төгрөгийн авлага нэмэгдэж, Ганган нүүр ХХК-ийн 31000.0 мянган төгрөгийг барагдуулж санхүүжилтийн дутуу 6000.0 мянган төгрөгийн өглөгийг бүртгэсэн. 98337.8 мянган төгрөгийн авлага бүртгэгдсэн.

Орон нутгийн хөгжлийн сангийн гүйцэтгэлд ҮАГ-ын нэгдсэн удирдамжаар гүйцэтгэлийн аудит хийгдэж байгаа тул уг сангаас хийгдсэн ажлын гүйцэтгэлийг шалгаагүй болно.

6. Эм эргэлтийн сангийн үйл ажиллагааг Эс-Эм аудит ХХК-нь гэрээний дагуу аудит хийж дүгнэлт гаргаж байгаа болно.

Долоо. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн дагуу 2015 оноос “shilendans.gov.mn” цахим сайтад зохих мэдээллийг оруулсан. ҮАГ-аас нэгдсэн удирдамжаар шилэн дансны хэрэгжилтэнд 2016 оны 10-р сарын байдлаар гүйцэтгэлийн аудит хийгдсэн. Тус аудитаар Засаг дарга

байгууллага нь шилэн дансанд 28 мэдээлэл байршуулахаас 11 мэдээллийг байршуулаагүй байсан байна.

Найм. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын эрсдэлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд батлагдсан төлөвлөгөөний дагуу гүйцэтгэлийн шатанд орон нутгийн төсвийн орлогын болон тусгай зориулалттай сангуудын мөнгөн хөрөнгө, орлого, зардлын дансдад 5 горим, сорил хэрэгжүүлэв.

Үр дагаварыг тодорхойлж чадвал: Эдгээр эрсдэлүүд нь Засаг даргын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд төсөвт байгууллагууд болон тусгай сангуудын санхүүгийн тайланг нэгтгэхдээ 2015 оны жилийн эцсийн аудитлагдсан санхүүгийн тайланд хийгдсэн залруулгыг Засгийн газрын Э-тайланд нэмж оруулаагүйгээс нэгтгэсэн тайлангийн оны эхний үлдэгдэл зөрүүтэй, мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг дутуу тайлагнасан, татварын орлогын мэдээг зөрүүтэй мэдээлсэн зэрэг нь муу үр дагаварт хүрч болзошгүй байна

Ёс. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

Төв аймгийн Эрдэнэ сумын Засаг даргын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад цаг хугацааны хязгаардагдмал байдлаас шалтгаалан сумын орон нутгийн төсөвт төвлөрөх орлогын төлөвлөгөөний биелэлт, аудитлагдсан санхүүгийн тайланг үнэн зөв нэгтгэсэн байдал, тусгай сангуудын харилцах дансны ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Арав. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв.

Аудитын явцад материаллаг хэмжээний дараах алдаа илэрсэн байна. Үүнд:

1. Орон нутгийн төсвийн орлогын дансанд төвлөрсөн 141763.8 мянган төгрөгийн орлогоос, татварын байцаагчийн орлогын төлөвлөгөөний гүйцэтгэл 137515.5 мянган төгрөг буюу 4248.3 мянган төгрөгөөр дутуу 5 нэр төрлийн орлогыг зөрүүтэй мэдээлсэн. Татварын байцаагчийн 2016 оны 12-р сарын төсвийн орлогын төлөвлөгөөний гүйцэтгэлийн мэдээгээр 13 нэр төрлийн орлогоор 151372.9 мянган төгрөг төвлөрүүлэхээс, гүйцэтгэлээр 137515.5 мянган төгрөг төвлөрч төлөвлөгөөний биелэлт 90.8 хувь байна. 13 нэр төрлийн орлогоос 3 нэр төрлийн орлого 100-аас дээш хувиар давж биелэж, 10 нэр төрлийн орлого 46535.3 мянган төгрөгөөр тасарсан. Төсвийн тухай хуулийн 16.5.7.байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах;, Санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Сумын орон нутгийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг сар тутамд анхан шатны баримт, төрийн сангийн хуулгын дүнд тулгуурлан,

татварын байцаагчийн мэдээг нэр төрөл, дүнгийн хувьд хянаж үнэн зөв мэдээлж байх зөвлөмж өгөв

2. МХСанд оны эхэнд 2601.0 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй авлагыг барагдуулах талаар тайлант онд тодорхой ажил зохиогоогүй, хэн хариуцах эзэн тодорхойгүй авлага үлдэгдлээр тайлагнагдсан. НББ-ийн тухай хуулийн 20.2.5.дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах, Санхүүгийн тайлангийн оршин байх, тохиолдсон байх, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Авлагыг барагдуулах төлбөрийн акт бичив

3. 2015 онд Хөдөлмөрийн хэлтсээс СХСангийн эх үүсвэрээр 21000.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг бэлтгэн нийлүүлсэн. Үүнээс 6 хүнд 8669.7 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг түрээсээр өгч авлагаар бүртгэсэн ба 12330.3 мянган төгрөгийн түрээсээр олгогдоогүй тоног төхөөрөмжийг бараа материал дансанд бүртгээгүй. НББ-ийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.2.6-д эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн: 12330.3 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг иргэдэд эзэмшүүлэх ба данс бүртгэлд тусгах албан шаардлага өгөв

4. СХСангийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн авлагын эцсийн үлдэгдэл 246906.2 мянган төгрөгийн 217442.8 мянган төгрөг нь буюу 88.1 хувь нь хугацаа хэтэрсэн. 2016 оны 8-р сард олгосон 22600.0 мянган төгрөгний хүүг ашигласан сараар тооцолгүй, бүтэн жилээр жилийн 3 хувиар буюу 678.0 мянган төгрөгийн хүү тооцож, 477.0 мянган төгрөгөөр хүүг илүү тооцсон. Өмнөх онуудад авсан зээлийн дүнгээс хүү тооцон бүртгэж байгаагүй ба аудитын явцад нягтлан бодогчоор өмнөх онуудын зээлийн хүүг тооцуулахад 8289.8 мянган төгрөгийг зээлийн хүүг тооцон бүртгээгүй байна. НББ-ийн тухай хуулийн 20.2.5.дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах, Санхүүгийн тайлангийн оршин байх, тохиолдсон байх, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: СХСангийн хугацаа хэтэрсэн авлага 217442.8 мянган төгрөгийн өмнөх онуудад тооцоогүй 8766.8 мянган төгрөгийн зээлийн хүүг нэмж тооцон барагдуулах талаар тодорхой ажил зохиож үр дүнг тайлагнах албан шаардлага өгөв.

5. ГХУССангийн оны эхний үлдэгдэл 1190.0 мянган төгрөгийн бараа материалыг ИТХ-ын бараа материалын дансанд шилжүүлэн бүртгээгүйгээр данснаас хассан нь НББ-ийн тухай хуулийн 20.2.5.дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах, Санхүүгийн тайлангийн оршин байх, тохиолдсон байх, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: ИТХ-ын бараа материалын дансанд бүртгүүлэхээр албан шаардлага бичив.

Материаллаг бус алдаа

6. ОНХСан нь оны эхэнд 1836.2 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байсан ба тайлант онд 89380.1 мянган төгрөгийн санхүүжилт болон газрын дуудлага худалдааны анхны үнэ /ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2012 оны 77 дугаар тогтоолоор тооцсон/, газрын суурийн үнийн орлого 17191.5 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор тайлагнасан.

Шийдвэрлэсэн: Газрын суурь үнийн орлогыг ОНХСангийн дансанд төвлөрүүлж байгаа зөрчлийг арилган, орон нутгийн төсөвт төвлөрүүлэн хуваарилах зөвлөмж өгөв

Арван нэг. Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Материаллаг бус залруулагдаагүй алдаа байхгүй болно.

Арван хоёр. Анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

Арван гурав. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Тухайн аудитын хамрах хүрээний асуудлыг аудитын хугацаанаас шалтгаалж эхний 9 сарын байдлаар завсарын аудит хийгдсэн тул тус аудитын дүгнэлтэнд тулгуурлан аудитыг хийсэн болно.

Арван дөрөв. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Төв аймгийн Эрдэнэ сумын Засаг даргын 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар материаллаг хэмжээний 293114.5 мянган төгрөгийн, материаллаг бус 17191.5 мянган төгрөгийн нийт 310306.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрсэн байна.Үүнд:

1. Материаллаг хэмжээний нийт 293114.5 мянган төгрөгийн алдаа, зөрчлийг таслан зогсоох давтан гаргахгүй байх 2601.0 мянган төгрөгийн төлбөрийн акт, 239729.9 мянган төгрөгийн албан шаардлага өгч залруулагдаагүй алдаа нь урьдчилан тогтоосон материаллаг байдлын түвшингээс хэтэрсэн тул батлагдсан орон нутгийн төсвийн орлого, Сум хөгжүүлэх сангийн зээл эргэн төлөлтийн хувьд Хязгаарлалттай санал дүгнэлт өгөхөөр шийдвэрлэсэн.
2. Материаллаг бус 17191.5 мянган төгрөгийн алдаанд зөвлөмж өгөв.

Арван тав. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Төв аймгийн Эрдэнэ сумын Засаг даргын 2015 оны санхүүгийн тусгай сангуудын тайланд өгсөн зөвлөмжийн биелэлтийг хугацаанд нь ирүүлсэн.

Арван зургаа. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт **Хязгаарлалттай санал дүгнэлт**

Төв аймгийн Эрдэнэ сумын Засаг даргын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд Орон нутгийн төсвийн орлогын дансанд төвлөрсөн орлогыг 4248.3 мянган төгрөгөөр дутуу

зөрүүтэй мэдээлсэн, 10 нэр төрлийн орлого 46535.3 мянган төгрөгөөр тасарсан, Сум хөгжүүлэх сангийн зээлийн авлагын 88.1 хувь буюу 217442.8 мянган төгрөг нь хугацаа хэтэрсэн зэрэг нь гүйцэтгэлийн шатанд дахин тогтоосон материаллаг байдлын түвшин 22587.1 мянган төгрөгнөөс хэтэрсэн тул Орон нутгийн орлого, сум хөгжүүлэх сангийн зээлийн авлагын барагдуулалтын хувьд “Хязгаарлалттай” санал дүгнэлт өгөхөөр шийдвэрлэсэн.

Дээрх алдаа, зөрчлийг эс тооцвол Төв аймгийн Эрдэнэ сумын Засаг даргын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг авч үзэхэд:

- ИТХурал нь “Зөрчилгүй” санал дүгнэлттэй
- ЗДТГазар нь “Зөрчилгүй” санал дүгнэлттэй
- ЕБСургууль нь “Зөрчилгүй” санал дүгнэлттэй
- Цэцэрлэг нь “Зөрчилгүй” санал дүгнэлттэй
- Соёлын төв нь “Зөрчилгүй” санал дүгнэлттэй
- ЭМТөв нь “Зөрчилгүй” санал дүгнэлттэй

Аудитлагдсан санхүүгийн тайлан 12 хуудас, байгууллагын санал .. хуудсыг тус тус хавсаргав.

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Л.ЖАРГАЛСАЙХАН

АУДИТЫН МЕНЕЖЕР

О.АМАРЖАРГАЛ

БЭЛТГЭСЭН: АУДИТОР

Т.МАЙЦЭЦЭГ